



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 8/19

Дэлгэрхаан сум

Сургалтын орчинд гар утасны
хэрэглээг хязгаарлах тухай

Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 33-р зүйлийн 33.3.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6, 2018 оны 09-р сарын 05-ны өдрийн Засгийн газрын 276-р тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн орчинд хичээл сургалтын үеэр багш, сурагчид ухаалаг гар утас ашиглахыг 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн хязгаарласугай.

2. Сурагчдад ухаалаг утас сургууль дээр авч ирэхгүй байх, түүнтэй адилтгах төхөөрөмжийн хэрэглээг хязгаарлаж байгаатай холбоотойгоор гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх талаар холбогдох журам боловсруулж эцэг, эх асран хамгаалагч нарт танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг анги удирдсан багш нар болон сургуулийн нийгмийн ажилтанд үүрэг болгосугай.

3. Сурагчдын дунд ухаалаг утас болон цахим сүлжээний ёс зүйтэй хэрэглээг хэвшүүлэх хүрээнд цахим хүчирхийлэл, халдлагаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг таниулахыг эрүүл мэнд, иргэний ёс зүйн боловсролын багш нарт, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавихыг нийгмийн ажилтан (С.Саранчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Ш.ЦЭРЭНДУЛАМ

This PC/Duc/Тушаал 2025

20250915